

АХМАДЫН ҮНДЭСНИЙ ЧУУЛГАНЫ ЗӨВЛӨМЖ



Холбооны удирдах зөвлөлийн гишүүн
Ахмад шүүгч Д.Дамдин-Од



АХМАДЫН ҮНДЭСНИЙ ЧУУЛГАН





АХМАДЫН ҮНДЭСНИЙ ЧУУЛГАН

ТӨРИЙН ОРДОН

“ИХ МОНГОЛ” ТАНХИМ

2025 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 08-НЫ ӨДӨР



АХМАДЫН ҮНДЭСНИЙ ЧУУЛГАН
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ДАРГА ДАШЗЭГВИЙН
АМАРБАЯСГАЛАНГИЙН ИВЭЭЛ
ДОР ЗОХИОН БАЙГУУЛАГДСАН.

ҮНДЭСНИЙ ЧУУЛГАНД МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР
АХМАДЫН ЭРХ, НИЙГЭМ ХАМГААЛЛЫН ЧИГЛЭЛЭЭР ҮЙЛ
АЖИЛЛАГАА ЯВУУЛДАГ ТӨРИЙН БОЛОН ТӨРИЙН БУС
БАЙГУУЛЛАГУУД, АХМАДЫН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ
ДЭМЖИН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛДАГ АЖ АХУЙН НЭГЖ,
ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГУУД БОЛОН МОНГОЛ УЛСЫН
ӨНЦӨГ БУЛАН БҮРЭЭС ИРСЭН 1000 ОРЧИМ ТӨЛӨӨЛӨГЧ
ОРОЛЦОВ.





ЧУУЛГАНААР:

- АХМАД НАСТНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ,
- АХМАД НАСТНЫ НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ТАЛААР
ТӨРӨӨС БАРИМТАЛЖ БУЙ БОДЛОГЫГ ОНОВЧТОЙ БОЛГОЖ,
ШИНЭЧЛЭХ,
- ТӨРӨӨС ЦААШИД АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЛААР
ДЭЛГЭРЭНГҮЙ ХЭЛЭЛЦСЭН.

АХМАДЫН ҮНДЭСНИЙ ЧУУЛГАНЫ ЗӨВЛӨМЖ



АХМАДЫН ҮНДЭСНИЙ
ЧУУЛГАН НИЙТ 5 ЧИГЛЭЛЭЭР
ЗӨВЛӨМЖ ГАРГАСАН.



Нэг.МОНГОЛ УЛСЫН ИХ
ХУРАЛД ХАНДСАН
ЗӨВЛӨМЖ-3



1.НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН НӨХЦӨЛ
БАЙДАЛ, ИНФЛЯЦЫН ТҮВШИНТЭЙ
УЯЛДУУЛАН ТЭТГЭВРИЙН ХЭМЖЭЭГ
ТОГТМОЛ НЭМЭГДҮҮЛЭХ ТОГТОЛЦООГ
БОЛОВСРОНГҮЙ БОЛГОХ.



2.АХМАД НАСТАНД ТӨРӨӨС ҮЗҮҮЛЭХ ДЭМЖЛЭГ,
АХМАДЫН АМЬЖИРГАА, ЭРҮҮЛ МЭНДИЙГ
ДЭМЖИХ, ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ, НИЙГМИЙН
НЭМЭГДҮҮЛЭХ ТАЛААРХ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН
БИЕЛЭЛТЭНД УЛСЫН ИХ ХУРЛЫН ХЯНАЛТ
ШАЛГАЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ



3.УИХ-ЫН ГИШҮҮДИЙН
БАЙГУУЛСАН АХМАД НАСТНЫ
ОРОЛЦООГ ДЭМЖИХ БҮЛЭГ,
АХМАДЫН БАЙГУУЛЛАГА,
ХОЛБООДТОЙ ХАМТРАН АЖИЛЛАХ.



Хоёр: ЗАСГИЙН ГАЗАРТ ХАНДСАН ЗӨВЛӨМЖ-20



1.АНТХ-ийн хэрэгжилтийг хангах
чиглэлээр төрийн байгууллагын үйл
ажиллагаа, зохион байгуулалтын
бүтцийг бүрдүүлэн хэрэгжилтыг
Р чимжүүлэх.

2.Ахмад настанд чиглэсэн салбар
дундын бодлогын уялдааг
сайжруулах, эрүүл мэнд, нийгмийн
хамгаалал, хөдөлмөр эрхлэлт,
нийгмийн оролцоог нэмэгдүүлэх.

3.Гэр бүл хөгжлийн цогц үйлчилгээний
төвийг бүх аймаг, дүүрэгт төр, хувийн
хэвшлийн түншлэлээр ажиллуулах,
Хөгжлийн төвийн барилгыг шинээр
барих ажлыг 2025 онд эхлүүлэх.



4.Эрүүл насжилтын 2024-2028
оны үндэсний төлөвлөгөөг
баталж хэрэгжүүлэх.



5.Идэвхитэй насжилтыг дэмжих
бодлого боловсруулж баталж
хэрэгжүүлэх.



6.Идэвхитэй насжилтыг дэмжих цогц үйлчилгээ үзүүлэх төвүүдийг аймаг, сум, дүүрэгт байгуулах, орон нутгийн ахмадын байгууллагын хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх, ахмад настанд сэтгэл зүйн дасан зохицох чиглэлээр сургалт, зөвлөгөө өгөх үйлчилгээг бий болгох.



7.Ахмад настны эрүүл мэндийг
хамгаалах чиглэлээр аймаг, сум,
дүүргийн эмнэлэг, эрүүл мэндийн
төвүүдэд ахмадын тасаг,
геронтологийн төвийг байгуулах.

8.Геронтологи-гериатрын хүний нөөцийг
мэрэгшүүлэх, энэ чиглэлийн эмчийн цагийн
хөлс, урамшууллыг нэмэгдүүлэх, эрүүл
мэндийн төвүүдэд ахмадын сэргээн засах
тасаг нээж, зөвхөн мэргэжлийн эмчээр
үйлчилгээ үзүүлдэг болох.



9.Ахмад настанд үйлчилгээ үзүүлэх
анхан шатны эрүүл мэндийн
байгууллагын үзлэг, эмчилгээ, асран
сувилах үйлчилгээний санхүүжилтийг
нэмэгдүүлэх,



10.Ахмад настанд хөнгөлөлттэй
үнээр олгодог эмийн төрөл болон
үнийн хөнгөлөлтийн хувийг
НЭМЭГДҮҮЛЭХ.



11.Ахмад настны асаргаа,
сувилахуйн хүний нөөцийн
хомсдолыг арилгаж, бүх шатны
эмнэлэгийг ахмад настны эмч,
сувилагчтай болгох.

12.Ахмад настны цогц үнэлгээ хийх, тусламж тусламж үйлчилгээ үзүүлэх ажлыг улсын болон орон нутгийн хэмжээнд нэгдсэн удирдлага, зохион байгууллалтаар хангах, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх чадавхыг бэхжүүлэх.



13.Ахмад настны хөдөлмөр
эрхлэлтийг дэмжих үндэсний
хөтөлбөр боловсруулж
хэрэгжүүлэх.

14.Ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд төрөл бүрийн сургалт, зөвлөх үйлчилгээ үзүүлэх ажлын хөлсийг зах зээлийн үнийн өсөлттэй уялдуулах, ахмадын сангаас идэвхитэй насжилтыг дэмжих сургагч багш нарын цалин урамшууллыг олгох зэрэг ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг бодитой дэмжих.

15.боловсрол, эрүүл мэнд, байгал орчин
аялал жуулчлал, хүнс хөдөө аж ахуйн
асуудал эрхэлсэн төсвийн ерөнхийлөн
захирагчдын төсвийн багцад ахмад настныг
ажиллуулах ажлын байрны хүртээмжийг
нэмэгдүүлэх төсөл, арга хэмжээг
хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг тусгах.

16.Тэтгэвэрт гарсан эмч, багш
нарыг тухайн салбарт нь
үргэлжлүүлэн ажиллуулах арга
хэмжээний төлөвлөгөөг
боловсруулж батлах.

17.Ногоон хувьсгал, ногоон ажлын
байранд ахмад настны оролцоог
нэмэгдүүлэх.



18.Түрээсийн орон сууц
хөтөлбөрийн хэрэгжилтэнд үнэлгээ
хийж, ахмад настныг хамруулах,
хүртээмжийг нэмэгдүүлэх, дэмжлэг
үзүүлэх.

19.Ахмад настны хувийн
асрамжийн газрын үйл
ажиллагааг төрөөс дэмжих.

20. 50 ба түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж байгууллага нийт ажлын байрныхаа 2 хувиас доошгүй орон тоонд ахмад настэыг ажиллуулах тухай хуулийн заалтын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллах.

Гурав.НИЙСЛЭЛ, ОРОН НУТГИЙН
ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА
БОЛОН ТӨРИЙН
БАЙГУУЛЛАГУУДАД ХАНДСАН
ЗӨВЛӨМЖ-9



1.Ахмад настны тухай хуулийг хэрэгжүүлэх
хүрээнд орон нутгийн төрийн болон төрийн бус
байгууллага, аж ахуйн нэгжид сургалт,
сурталчилгаа хийх, хэвлэл мэдээллийн
хэрэгслээр олон нийтэд чиглэсэн нөлөөллийн
ажил зохион байгуулах.

2.Ахмадын өдрийг жил
бүрийн 10 дугаар сарын
эхний долоо хоногт зохион
байгуулж хэвших.

3. "АХМАДЫН ӨРГӨӨ" бусад төвүүд нь төрийн болон орон нутгийн өмчит барилга байгууламжид байрлан үйл ажиллагаа явуулж байгаа бол тус үл хөдлөх хөрөнгийн ашиглалт, засварын зардлыг гэрээний үндсэн дээр орон нутгийн төсвөөс хэсэгчилэн, эсхүл бүрэн санхүүжүүлэхтэй холбогдсон зардлыг орон нутгийн төсөвт тусгах.

4.Нийт хүн ам болон ахмад настанд эрүүл
насжилтын талаархи мэдлэг ойлголтыг
нэмэгдүүлэх чиглэлээр сургалт,
сурталчилгааны ажлыг хороо, багийн
өрхийн эрүүл мэндийн төвүүдийг түшиглэн
тогтмол зохион байгуулах.

5. Оршин суух бүртгэлгүй ахмадыг харьяалах сум, хороо, багууд бүртгэлд хамруулж Ахмад настны тухай хуульд заасан хүндэтгэлийн арга хэмжээнд хамруулах болон бусад шаардлагатай нийгмийн үйлчилгээ үзүүлэх.

6.Ахмадын сан байгуулан ажиллуулах,
тэтгэвэрт бэлтгэх төлөвлөгөөг
хэрэгжүүлэхэд төсөвт байгууллага болон
аж ахуйн нэгж байгууллагатай хамтран
ажиллах, хяналт тавих.

7.Ахмад настны эсрэг гэр бүлийн хүчирхийлэл, тэтгэвэр тэтгэмж, эдийн болон эдийн бус хөрөнгийн эзэмших, ашиглах эрхийн зөрчил, гэм хорын талаар мэдээлэх дуудлагын тусгай утсыг ажиллуулах, иргэд олон нийт, ахмад настанд таниулах хүргэх.

8.Ахмад настны асрамжийн үйлчилгээ
шинээр үзүүлэх байгууллагад газар
эзэмшүүлэх талаар тухайн жилийн газар
зохион байгуулалтын төлөвлөгөөндөө
тусган дэмжлэг үзүүлэх.



9.Ахмад настнаа хүндлэх, ёс заншил, уламжлалаа өвлүүлэх, мэдлэг туршлагыг нь залуу үед хүргэх арга хэмжээг зохион байгуулах, ахмад настныг ажиллаж байсан байгууллага болон бүх шатны боловсролын байгууллагад тогтмол сургалт хийлгэх, ахлах ангийн сурагч, оюутнуудыг ахмад настанд технологийн, цахим орчин, цахим үйлчилгээний сургалт явуулах зэрэг сайн дурын ажилд татан оролцуулах, урамшуулах.

Дөрөв.АХМАДЫН ХОЛБОО, ТӨРИЙН
БУС БАЙГУУЛЛАГА, ХУВИЙН
ХЭВШЛИЙН БАЙГУУЛЛАГУУДАД
ХАНДСАН ЗӨВЛӨМЖ-3



1.Ахмадын чиглэлээр үйл
ажиллагаа явуулж буй холбоо,
төрийн бус байгууллагууд
ахмадын нийтлэг арх ашгийг
хамгаалж нэгдмэл байх.

2.Ахмадын байгууллага, холбоодын
үйл ажиллагаанд ахмадын оролцоог
нэмэгдүүлэх, эрх, хууль ёсны ашиг
сонирхлыг бодитой хамгаалах арга
хэмжээг хэрэгжүүлэх.

3.Аж ахуйн нэгж байгууллагууд АХмад настны тухай хуульд заасны дагуу “АХМАДЫН САН” байгуулах, ажлын байранд ахмад настныг ажиллуулахтай холбоотой зохицуулалтын хэрэгжилтыг хангаж ажиллах, харьяалах орон нутгийн захиргааны байгууллагад тайлагнах.

4.АХмад мэргэжилтний
зөвлөх үйлчилгээг дэмжиж,
цалин, урамшуулал олгох
тогтолцоог бүрдүүлэх.

5.Ахмад ажилтны ажил, амьдралын мэдлэг туршлага, сургаалыг хүүхэд залууст үлгэрлэн таниулах, ахмад-залуу үеийн холбоог бэхжүүлэх, ахмад настныг хүндэтгэх соёл уламжлал, ёс заншлыг залуу хойч үед өвлүүлэхэд чиглэсэн аян өрнүүлэх, контент нэвтрүүлэг бэлтгэн олон нийтэд хүргэх.

6. "Угийн бичиг"-ийг айл өрх бүрт хөтлүүлж хэвшүүлэх, угийн бичиг хөтлөх үндэсний түүхэн уламжлалыг сэргээн хөгжүүлэхийг монголын нийт иргэдэд уриалах арга хэмжээг зохион байгуулан хэрэгжүүлэх.



Тав.ОЛОН НИЙТ,
АХМАДУУДАД ХАНДСАН
ЗӨВЛӨМЖ-4



1.Ахмад настны ажил, амьдралын мэдлэг туршлага, сургаалыг хүүхэд залууст үлгэрлэн таниулах, ахмад настны сургаал баялаг туршлагаас суралцах, ахмад настныг хүндэтгэн дээдлэх.



2.Түүх соёл, уламжлалт ёс заншлаа
залуу хойч үедээ өвлүүлэх,
залуучуудыг ажлын байранд
бэлтгэхэд мэдлэг туршлагаа
хуваалцаж хамтран ажиллах.

3.Залгамж хойч үеэ өв соёл, эрдэм
боловсролыг дээдэлдэг, амьдрах арга
ухаанд суралусан, удам угсаа, эх орондоо
үнэ цэнэтэй иргэн болж хүмүүжин
төлөвшихөд нь дэмжин тусалж байх.

Нэг.МОНГОЛ УЛСЫН ИХ
ХУРАЛД ХАНДСАН
ЗӨВЛӨМЖ-3



4.Эрүүл монгол хүнийг төлөвшүүлэхэд залуу үеэ үлгэрлэх.



АНХААРЛАА ХАНДУУЛСАНД ГЯЛАЙЛАА

